



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 07 өдөр

Дугаар A/27

Улаанбаатар хот

Г Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2016 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн A/08 дугаар тушаалын 1.А-д заасан Хавдар судлалын үндэсний төвийн өргөтгөлийн хэсэг ашиглалтад орсонтой холбогдуулан гарах зардалд 700,000,000.00 /долоон зуун сая/ төгрөгийг Хавдар судлалын үндэсний төв /Л.Төмөрбаатар/-д зарцуулах эрхийг шилжүүлсүгэй.

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулан ажиллахыг Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирал /Л.Төмөрбаатар/-д үүрэг болгосугай.

3. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан ажлын гүйцэтгэл, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга /С.Төгсдэлгэр/, Стратеги бодлого, төлөвлөлтийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Баярсайхан/ нарт үүрэг болгосугай.

САЙД

А.ЦОГЦЭЦЭГ



080107